



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/19

Мөрөн сум

Тусгай зөвшөөрлийн нэмэлт өөрчлөлт
оруулах шинээр олгох, чиглэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.5, 19.17, 19.18, Захиргааны ерөнхий хуулийн 40 дугаар зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 400 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинээр эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох аж, ахуйн нэгж байгууллагын жагсаалтыг 1 дүгээр, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах аж ахуйн нэгж байгууллагын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/66 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын 3 дугаар багананд заасан “Эрхлэх үйл ажиллагааны чиглэл” гэсэн хэсгийн дотор, мэдрэлийн амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ гэснийг “дотрын амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ” гэж, аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/288 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтын 3 дугаар багананд заасан “Эрхлэх үйл ажиллагааны чиглэл” гэсэн хэсгийн мэс засал, дотор, чих хамар хоолойн амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ. Чих хамар хоолойн мэс засал гэснийг мэс засал, дотор, чих хамар хоолой, сэргээн засах, уламжлалт эмчилгээ, мэдрэл, нүд, амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, Чих хамар хоолойн мэс засал гэж, аймгийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/416 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 5 дугаар багананд заасан “Ажлын байрны хаяг” гэсэн хэсгийн Мөрөн сум 9 дүгээр баг 9-42-1 гэснийг 12 дугаар баг 12-14-28 гэж тус тус өөрчилсүгэй.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаяр), Эрүүл мэндийн газар (М.Үүрийнбаяр) нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн багц хууль, эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудад холбогдох стандарт, эмнэл зүйн удирдамжуудыг мөрдөж ажиллахыг эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд даалгасугай.

5. Энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохийг дурьдсугай.

6. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр
сарын 21-ны өдрийн 4/19 захирамжийн
1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР
ОЛГОХ БАЙГУУЛЛАГА

	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Эрхлэх үйл ажиллагааны чиглэл	Ажлын байрны хаяг	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	"Тэгш цагаан" ХХК "Бэст сайхан" эмнэлэг	Ч.Оюунтуяа	Нүүр амны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эмнэлэг	Мөрөн сум 7 дугаар баг 23 дугаар гудамж 19А Сайхан төвийн байр	2022-01-21 2025-01-21
2	"Голден фарм" ХХК- ний "Голденфарм" эмийн сан	Б.Содномпил	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Мөрөн сум 4 дүгээр баг 20 дугаар гудамж "Эрхэс" , худалдааны төвийн байр	2022-01-21 2025-01-21
3	"Агьт тун" ХХК-ны "Агьт тун" эмийн сан	Р.Баярмаа	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Улаан-Уул сум 5 дугаар баг	2022-01-21 2025-01-21

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2022 оны 01
дүгээр сарын 29-ны өдрийн 1/19
захирамжийн 2 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ
БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Эрхлэх үйл ажиллагааны чиглэл	Ажлын байрны хаяг	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	"Энх-Алгана" ХХК Энхнаран эмнэлэг	Д.Энхтайван	Дотрын эмнэлгийн үйл ажиллагаа	Мөрөн сум 8 дугаар баг "Тана" эмнэлгийн байр	2021-11-18 2026-11-18
2	"Ончинжалба" ХХК Ончинжалба уламжлалтын эмнэлэг	Д.Эрдэнэ-Очир	Уламжлалт эмнэлгийн үйл ажиллагаа	Мөрөн сум 6 дугаар баг 8-ын 1 тоот	2021-11-18 2026-11-18
3	"Монос хөвсгөл" ХХК Монос эмийн сан	Ш.Тунгалаг	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Мөрөн сум 6 дугаар баг "Номин" агуулах худалдааны байр	2022-01-11 2027-01-11
4	"Хөгжил мөрөн" ХХК-ны "Үлэмж" эмийн сан	Г.Долгион	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Мөрөн сум 5 дугаар баг "Цагаан-Уул" зах дотор	2021-11-03 2026-11-03
5	"Бүрд-Очир" ХХК-ны "Бүрд" Эмийн сан	Н.Энхзаяа	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Мөрөн сум 7 дугаар баг 10 дугаар гудамж 26 тоот	2021-11-03 2026-11-03
6	"Агар тунамал" ХХК-ийн Энэрэл дент эмнэлэг	Б.Энхсайхан	Нүүр амны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эмнэлэг	Мөрөн сум 8 дугаар баг 10-25 тоот	2021-11-03 2026-11-03
7	"Бухлаг" ХХК-ны "Энхийн тун" эмийн сан	Д.Мандах	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Баянзүрх сум 5 дугаар баг "Бэлтэс" 5-12 тоот	2021-11-23 2026-11-23
8	"Номин Үрэл" ХХК-ны "Үрэл" эмийн сан	Р.Алтанцэцэг	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Тариалан сум 1 дүгээр баг "Мандал шивэрт" 4-1 тоот	2021-11-03 2026-11-03